

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МЯНГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/40/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjav.b@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<i>НДШ</i>	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
<i>ХХОАТ</i>	<i>Хувь хүний орлогын албан татвар</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

45



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

**МЯНГАД СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.УЛААНХҮҮ ТАНАА**

2021.03.22 № 4/170
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд ил тод, тэгш хүргэх зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

021020731

24

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49,016,865.59	87,695,234.73
33	АВЛАГА	8,252,220.59	41,525,986.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,200,860.20	3,629,645.54
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	85,000.00	85,000.00
335	Бусад авлага	2,966,360.39	37,811,341.20
3351	Байгууллагаас авах авлага	1,941,360.39	32,610,481.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,025,000.00	5,200,860.20
34	УРЬДЧИЛГАА	30,500,000.00	30,500,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	30,500,000.00	30,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,264,645.00	15,669,247.99
354	Хангамжийн материал	8,014,645.00	15,669,247.99
35420	Аж ахуйн материал	8,014,345.00	15,668,936.00
35440	Түлш, шатах тослох материал	300.00	311.99
35600	Мал амьтад	2,250,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	809,375,506.23	1,377,886,225.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	809,375,506.23	1,377,886,225.34
392	Биет хөрөнгө	768,335,506.23	1,337,033,725.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,137,574,018.50	1,418,978,536.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-496,589,881.91	-573,020,111.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,159,950.00	94,459,950.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-53,729,432.56	-39,937,754.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	155,160,564.00	170,494,127.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-117,197,708.56	-126,293,144.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,315,308.00	81,345,308.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,721,898.24	-51,130,441.60
39209	Зам, гүүрийн байгууламж	41,364,587.00	364,205,485.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-2,068,229.40
393	Биет бус хөрөнгө	41,040,000.00	40,852,500.00
39301	Програм хангамж	2,055,590.00	2,055,590.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,305,590.00	-1,493,090.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,290,000.00	40,290,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	858,392,371.82	1,465,581,460.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,630,375.93	198,190.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,630,375.93	198,190.00
413	Өглөг	1,630,375.93	198,190.00
4136	Бусад өглөг	1,630,375.93	198,190.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	38,004.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,630,375.93	160,186.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	856,761,995.89	1,465,383,270.07
51	Засгийн газрын хувь оролцоо	856,761,995.89	1,465,383,270.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	561,660,058.00	561,660,058.00
51101	Өмч: - төрийн	561,660,058.00	561,660,058.00
512	Хуримтлагдсан үр дүн	-126,195,654.19	482,425,619.99
51210	Өмнөх үеийн үр дүн	-126,195,654.19	-125,265,278.26
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	607,690,898.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	421,297,592.08	421,297,592.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	858,392,371.82	1,465,581,460.07

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	603,962,433.50	1,135,931,685.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,374,985.00	554,477,979.00
120	Нийтлэг татварын бус орлого	116,374,985.00	554,477,979.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	116,374,985.00	554,477,979.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	723,300.00	344,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	115,651,685.00	554,133,979.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	487,587,448.50	581,453,706.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,911,548.50	209,525,706.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,878,637.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,911,548.50	203,647,069.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	323,435,600.00	371,928,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,435,600.00	359,148,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	25,240,300.00	12,780,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	908,361,141.70	524,074,119.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	908,361,141.70	524,074,119.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	884,920,841.70	499,517,618.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,180,380.00	235,200,933.00
210101	Үндсэн цалин	204,180,380.00	235,200,933.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,100,086.87	29,923,683.85
210201	Тэтгэврийн даатгал	26,100,086.87	29,923,683.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,307,607.00	25,217,023.31
210301	Гэрэл, цахилгаан	1,179,221.00	1,209,539.30
210302	Түлш, халаалт	15,267,600.00	19,784,188.01
210303	Цэвэр, бохир ус	3,860,786.00	4,223,296.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,706,794.00	25,882,915.00
210401	Бичиг хэрэг	3,936,300.00	1,941,341.00
210402	Тээвэр, шатахуун	15,710,429.00	13,586,815.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,510,400.00	2,318,559.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	19,549,665.00	5,786,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,250,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,768,300.00	1,745,000.00
210702	Дотоод албан томилолт	6,768,300.00	1,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,077,999.00	15,739,250.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,135,999.00	15,177,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	160,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000.00	54,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	239,000.00	200,000.00
210807	Газрын төлбөр	138,000.00	147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	556,779,674.83	165,808,813.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,068,441.00	64,577,221.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	484,711,233.83	101,231,592.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,440,300.00	24,556,500.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,440,300.00	22,789,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,220,300.00	22,514,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	220,000.00	275,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,767,100.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,767,100.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-304,398,708.20	611,857,565.33
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	32,840,900.00	4,166,667.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	32,840,900.00	4,166,667.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-32,840,900.00	-4,166,667.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-337,239,608.20	607,690,898.25

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	488,310,748.50	581,797,706.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	723,300.00	344,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	723,300.00	344,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	723,300.00	344,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	723,300.00	344,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	487,587,448.50	581,453,706.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,911,548.50	209,525,706.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,878,637.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,911,548.50	203,647,069.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	348,675,900.00	371,928,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,435,600.00	359,148,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	25,240,300.00	12,780,000.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	488,310,748.50	581,797,706.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,310,748.50	581,797,706.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464,890,448.50	557,241,205.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,167,900.00	234,455,900.00
210101	Үндсэн цалин	134,564,662.00	163,084,500.00
210102	Нэмэгдэл	34,306,771.00	43,308,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,296,467.00	28,063,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,485,000.00	31,651,400.00
210201	Тэтгэврийн даатгал	17,640,300.00	22,273,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,880,400.00	2,344,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,647,600.00	1,875,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	561,700.00	468,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,755,000.00	4,689,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,705,300.00	30,055,599.30
210301	Гэрэл, цахилгаан	3,846,221.00	2,765,199.30
210302	Түлш, халаалт	15,039,079.00	21,970,400.00
210303	Цэвэр, бохир ус	6,820,000.00	5,320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,226,200.00	20,038,200.00
210401	Бичиг хэрэг	3,105,600.00	3,199,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,727,300.00	13,395,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,393,300.00	3,443,900.00
2105	Нормативт зардал	402,000.00	402,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	402,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,342,700.00	1,175,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	3,142,700.00	975,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,723,300.00	1,745,000.00
210702	Дотоод албан томилолт	6,723,300.00	1,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,587,300.00	17,462,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,637,300.00	16,415,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	170,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000.00	275,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000.00	425,000.00
210807	Газрын төлбөр	138,000.00	147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149,250,748.50	220,255,806.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149,250,748.50	220,255,806.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,420,300.00	24,556,500.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,420,300.00	22,789,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,220,300.00	22,514,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	275,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,767,100.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,767,100.70
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	561,660,058.00	429,533,946.20	221,807,599.89	1,213,001,604.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-10,763,645.88	-10,763,645.88
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	211,043,954.01	211,043,954.01
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	-8,236,354.12	00.00	-8,236,354.12
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	337,239,608.70	-337,239,608.70
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	561,660,058.00	421,297,592.08	126,195,654.19	856,761,995.89
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	561,660,058.00	421,297,592.08	126,195,654.19	856,761,995.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	930,375.93	930,375.93
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	561,660,058.00	421,297,592.08	125,265,278.26	857,692,371.82
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	607,690,898.25	607,690,898.25
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	561,660,058.00	421,297,592.08	482,425,619.99	1,465,383,270.07

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

ЭЗА	Зардлын нэр	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,791,400.00	370,504,899.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	372,791,400.00	370,504,899.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	350,002,000.00	347,715,499.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234,455,900.00	234,455,900.00
210101	Үндсэн цалин	163,084,500.00	163,084,500.00
210102	Нэмэгдэл	43,308,400.00	43,308,400.00

210105	Гэрээт ажлын хөлс	28,063,000.00	28,063,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,651,400.00	31,651,400.00
210201	Тэтгэврийн даатгал	22,273,400.00	22,273,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,344,500.00	2,344,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,875,400.00	1,875,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	468,900.00	468,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,689,200.00	4,689,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,055,600.00	30,055,599.30
210301	Гэрэл, цахилгаан	2,765,200.00	2,765,199.30
210302	Түлш, халаалт	21,970,400.00	21,970,400.00
210303	Цэвэр, бохир ус	5,320,000.00	5,320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,038,200.00	20,038,200.00
210401	Бичиг хэрэг	3,199,000.00	3,199,000.00
210402	Тээвэр, шатахуун	13,395,300.00	13,395,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,443,900.00	3,443,900.00
2105	Нормативт зардал	402,000.00	402,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	402,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,842,700.00	1,175,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	1,642,700.00	975,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,654,400.00	1,745,000.00
210702	Дотоод албан томилолт	2,654,400.00	1,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,322,000.00	17,462,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,185,000.00	16,415,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	170,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	275,000.00	275,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	425,000.00	425,000.00
210807	Газрын төлбөр	147,000.00	147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,579,800.00	10,730,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,579,800.00	10,730,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,789,400.00	22,789,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,789,400.00	22,789,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,514,400.00	22,514,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	275,000.00	275,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	372,791,400.00	370,504,899.30
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	372,186,400.00	370,160,899.30
132001	Орон нутгийн төсвөөс	359,406,400.00	357,380,899.30
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	12,780,000.00	12,780,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000.00	344,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	344,000.00
	Төсвийн байгууллага	1	1

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	6	6

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	209,525,706.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	209,525,706.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	209,525,706.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	209,525,706.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	209,525,706.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	209,525,706.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,525,706.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,878,637.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	203,647,069.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байгууллагын дарга Ч.Улаанхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-наас 2021 оны 03 дугаар сарын 18-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должинжав хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь Ковид -19 цар тахлын нөхцөл байдлын улмаас хорио цээр тогтоосноос хамаарч хуулийн хугацаа хоцроож аудитад тайлангаа ирүүлсэн тул Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаа хоцорч тайланг баталгаажуулсан болно.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мянгад сумын Засаг даргын Тамгын газар нь “Тэгш хүртээмжтэй, ил тод, итгэл хүлээж, хэрэгцээнд нийцсэн чанартай үйлчилгээ үзүүлж, нийтийн сайн сайхан байдлыг бий болгож, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон ажилласан байна.

Сумын Засаг даргын Тамгын газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тодорхойлжээ. Үүнд:

1. Засгийн газрын бодлого шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах
2. Төрийн хууль тогтоомжийг сурталчлах хэрэгжүүлэх
3. Сумын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бүртгэл судалгааг хөтөлж, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр хангах
4. Сумын хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ковид-19 вирусны нөхцөл байдлын улмаас Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө дунд гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 404098.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4041.0 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 524374.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5243.7 мянган төгрөгөөр тооцсон болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 607189.1 мянган төгрөгөөр буюу 71% хувиар өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь авлага, үндсэн хөрөнгийн дансанд гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	49,016.9	87,695.2	38,678.4
33	Авлага	8,252.2	41,526.0	33,273.8
34	Урьдчилгаа	30,500.0	30,500.0	-
35	Бараа материал	10,264.6	15,669.2	5,404.6
39	Үндсэн хөрөнгө	809,375.5	1,377,886.2	568,510.7
3	Нийт хөрөнгийн дүн	858,392.4	1,465,581.5	607,189.1
4	Нийт өр төлбөр	1,630.4	198.2	-1,432.2
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	856,762.0	1,465,383.3	608,621.3
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	858,392.4	1,465,581.5	607,189.1

Авлагын дансны үлдэгдэл дэх 41526.0 мянган төгрөгийн 32251.8 мянган төгрөг нь сумын цэцэрлэгт хүрээлэнгийн урьдчилгаа санхүүжилтийг Шандны ус ХХК-д олгож авлагаар бүртгэсэн, 150.0 мянган төгрөг нь ажилчдаас авах цалингийн урьдчилгааны авлага, 2002.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 1477.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын илүү төлөлт, 85.0 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлага, 358.5 мянган төгрөгийн байгууллагаас авах тооцооны авлага, түүнчлэн он дамжсан эзэн холбогдогч, хариуцагч нь байхгүй 5200.9 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл дэх 30500.0 мянган төгрөгийн 10000.0 мянган төгрөг нь Алтайн сүрлэг цамхаг ХХК-аар гүйцэтгүүлсэн хүүхдийн цэцэрлэгийн зураг төсөл, 7500.0 мянган төгрөг нь Засаг даргын Тамгын газрын урсгал засварын зураг төсөл, 13000.0 мянган төгрөг нь сумын дулааны зураг төслийг урьдчилгаа дансанд бүртгэсэн байна. Тодруулбал:

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 10000.0 мянган төгрөгийн цэцэрлэгийн зураг төсвийн санхүүжилтийг төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосон боловч барагдаагүй байна.
- 7500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сумын ЗДТГ-ын барилгын их засвар”-ын зураг төсвөөр 2021 онд тухайн ажил хийгдэхээр хүлээгдэж байна.
- 13000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сумын дулааны шугам сүлжээ”-ний зураг төсвийг зорилтот ажилд ашиглаагүй, он дамжин урьдчилгаа тооцоогоор бүртгэгдсээр байна. Энэ нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулжээ.

Бараа материалын данс оны эхэнд 10264.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант оны үр дүнд 5404.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 15669.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болжээ. Хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Дүн
1	Оны эхний үлдэгдэл	10,264.6
2	Нэмэгдсэн	27,257.7
2.1	Худалдан авсан	22,257.7
2.2	Хандиваар	5,000.0
3	Хасагдсан	21,852.0
3.1	Худалдсан, зарцуулсан	19,602.0
3.4	Бусад	2,250.0
4	Эцсийн үлдэгдэл	15,669.2

Тайлант онд сумын ОНХС-аас 5000.0 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгажээ.

Бараа материалын данс бүртгэлд бодитоор оршин байхгүй 2250.0 мянган төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байсан ба сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 20-ны 28 дугаар тогтоол шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хассан байна.

Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулагдсан бараа материалын шинжтэй эд зүйлийг няравын тусгаагүй зөрчил илэрлээ.

Үндсэн хөрөнгө данс оны эхэнд 1522920,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 673909,0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 25000.0 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, оны эцэст 2171829.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Хуримтлагдсан элэгдлийг хассанаар оны эцэс дэх эргэлтийн бус хөрөнгийн цэвэр дүн 1377886.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	1,522,920.0
2	Нэмэгдсэн	673,909.0
2.1	Худалдан авсан	124,775.0
2.5	Бусад	549,134.0
3	Хасагдсан	25,000.0
303	Шилжүүлсэн	25,000.0
4	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,171,829.0
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	713,544.5
801	Элэгдлийн зардал тайлант хугацааны	101,231.6
9	Дансны хасалт	-20,833.3
10	Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	793,942.8
11	Үлдэгдэл өртөг	1,377,886.2

Тайланд онд нэмэгдсэн 673909.0 мянган төгрөгийн хөрөнгөөс 549134.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 124775.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч данс бүртгэлд тусгасан байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг дэлгэрэнгүй харуулбал:

- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 14889.6 мянган төгрөгөөр ЗДТГ-ын урьд талбай, 8000.0 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг, 9806.4 мянган төгрөгийн ЗДТГ-ын барилгын дээврийн засварын ажил, нийт 32696.0 мянган төгрөг,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 322840.9 мянган төгрөгийн хатуу хучилтай зам
- Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 145068.1 мянган төгрөгөөр сумын төвд пүү,
- Аймгийн мал эмнэлгийн газраас 6900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж,
- Аймгийн хөрөнгө оруулалтаар 3544.5 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 27908,9 мянган төгрөгийн худаг, багийн төвийн дутуу санхүүжилт 7675.5 мянган төгрөг, авто машины дутуу санхүүжилт 2500.0 мянган төгрөгийг үнэ төлбөргүй хөрөнгөөр хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгажээ.

Биет бус хөрөнгөд 2055.5 мянган төгрөгийн өртөгтэй, 1493.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй программ хангамж, 12 байршилд нийт 40290.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газар бүртгэлтэй байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл оны эхэнд 561660.0 мянган төгрөг байсан ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос 531969.3 мянган төгрөгөөр буюу 88.1 хувиар өссөн байна. Хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	603,962.4	1,135,931.7	531,969.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	723.3	344.0	(379.3)
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	115,651.7	554,134.0	438,482.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,911.5	209,525.7	70,614.2
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	323,435.6	359,148.0	35,712.4
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	25,240.3	12,780.0	(12,460.3)

Өмнөх оны үзүүлэлтээс орлого материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд үнэ төлбөргүй 554134.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, түүнчлэн төсвийн санхүүжилт өмнөх оноос 35712.4 мянган төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 384287.0 мянган төгрөгөөр буюу 42.3 хувиар буурсан байна.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	908,361.1	524,074.1	-384,287.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	884,920.8	499,517.6	-385,403.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,180.4	235,200.9	31,020.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,100.1	29,923.7	3,823.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,307.6	25,217.0	4,909.4
2104	Хангамж, бараа материалын зардал	41,706.8	25,882.9	-15,823.9
2107	Томилот, зочны зардал	6,768.3	1,745.0	-5,023.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,078.0	15,739.3	-13,338.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	556,779.7	165,808.8	-390,970.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,440.3	24,556.5	1,116.2

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол 383479.6 мянган төгрөгөөр буурсан боловч өмнөх онд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг алдаатай тайлагнаснаас шалтгаалж байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл дэх 198.2 мянган төгрөгийн 38.0 мянган төгрөг нь шатахууны өглөг, 160.2 мянган төгрөг нь ажиллагчидтай холбогдсон хамтын сангийн тооцоо байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд 1480.3 мянган төгрөгийн эзэн тодорхойгүй өр төлбөр, 550.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон авлагыг бууруулж, 930.4 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаанд залруулга хийсэн нь байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 474689.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 474689.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 101898.2 мянган төгрөгөөр бууруулж 372791.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 23510.5 мянган төгрөгөөр өсчээ. Үүнд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 36710.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4500.3 мянга, хангамж бараа материалын зардал 1194.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, эд хогшил урсгал засварын зардал 1500.0 мянга, томиллолт зочны зардал 4276.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 12273.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 138.2 мянга, урсгал шилжүүлгийн зардал 705.9 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 372791.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 359406.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 12780.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 605.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 359148.0 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 12780.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагаанаас 344.0 мянган төгрөгийн орлого, нийт 372272.0 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, 1767.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 370504.9 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь төсвийн зардлыг 2286.5 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
70106	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	231,107.8	229,337.5	(1,770.3)
70106	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, ү	14,417.9	14,417.9	-
70106	80106	Баг, хорооны ҮАЗардал	79,031.5	78,848.4	(183.1)
70106	80205	Мэдээлэл, сурталчилгааны зарда	125.0	125.0	-
70106	80305	Биеийн тамирын уралдаан, тэмцэ	223.0	223.0	-
70106	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	22,514.4	22,514.4	-
70106	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	4,500.0	4,500.0	-
70106	82212	Хур хог хаягдал, орчны бохирдл	1,500.0	1,166.9	(333.1)
70106	82801	Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	-
70801	82502	Мал эмнэлгийн ?йлчилгээ	12,780.0	12,780.0	-
71413	81701	Байгаль орчныг хамгаалах, нөхө	711.8	711.8	-
72208	80103	Ахмад насны хөгжил хамгаалал	160.0	160.0	-
72208	80221	Ахмад насны хөгжил хамгаалал	720.0	720.0	-
		ДҮН	372,791.4	370,504.9	(2,286.5)

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс 203647.1 мянга, бусад шатны төсвөөс 5878.6 мянган төгрөгийн санхүүжилтийг холбогдох хууль, журмын хүрээнд бүрдүүлжээ.

Дээрх 209525.7 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг зориулалтын дагуу холбогдох арга хэмжээнд зарцуулсан ч санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн тайланд зардлыг холбогдох эдийн засгийн ангиллаар бүртгэж тайлагнаагүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 2 мэдээллийг хугацаа хоцроож, 155 мэдээллийг хугацаанд нь оруулсан боловч зарим мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой байдал хангалтгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан хэрэгжүүлсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн тайланд тус байгууллагатай холбогдсон 3 зөвлөмж өгч, 2 төлбөрийн акт тогтоосон ба хэрэгжилт 58.5%-тай байгааг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	10490.5	1	490.5	1	10000.0	50%
Зөвлөмж	3	25557.9	2	5057.9	1	20500.0	67%
Нийт дүн	5	36048.4	3	5548.4	2	30500.0	58.5%

/мянган.төг

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21050.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4280.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 13000.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, 3770.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Он дамжин бүртгэгдсээр байгаа 1480.3 мянган төгрөгийн эзэн тодорхойгүй өр төлбөр,
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 онд хэрэгжүүлсэн хяналт, шалгалтаар ажилчидтай холбоотой 550.0 мянган төгрөгийн авлагад төлбөрийн акт тогтоосон учир,
- Бараа материалын данс бүртгэлд бодитоор оршин байхгүй 2250.0 мянган төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байсан ба сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 20-ны 28 дугаар тогтоол шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хасаагүй байсныг залруулж бүртгэсэн.

Нийт 4280.3 мянган төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчилд залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар дараах зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Эд хөрөнгийн тооллого хийсэн боловч, холбогдох тооцоо бодоогүй, тооллогын үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, мөн өмнөх онд сумын дулааны шугам сүлжээний зураг төсвийн ажлыг 13000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч зорилтот ажлыг тухайн зураг төсвөөр хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан, баланс дахь авлага, урьдчилгаа дансны тооцоог харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "Төсвийн захирагч нь төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6- д "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "4.1.1-д мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.2-д мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, 4.1.3-д тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 4.1.4-д хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 3770.0 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараах асуудалд гүйцэтгэлийн үе шатанд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, шийдэл гаргах нөхцөл боломж цаг хугацааны хувьд хүрэлцээгүй учир дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Тус байгууллага 2020 онд Тоосгон уул ХХК-ийн нэгдсэн халаалтын системээс дулааны эрчим хүчээр хангагдсан. Тухайн жилд ЗДТГ-ын барилгын халаалтын төсөв 21970.4 мянган төгрөг байхад Тоосгон уул ХХК-тай халаалтын үйлчилгээ авахаар 27228.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан байна. Гэвч хоорондын тооцоо нийлсэн актаар 5257.6 мянган төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаагүй,
- Бараа материал, шатахууны зарцуулалт, цалин хөлсний тооцоололд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлээгүй учир дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

1.1. Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.

1.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль, журам зөрчигдөх, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу "Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар зардлын эдийн засгийн ангилал баталсан шийдвэртэй тус тус нийцүүлэн төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зохих зардлын эдийн засгийн ангиллаас зарцуулж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах. Дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Төсвийн зарцуулалттай холбоотой

2.1. Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд үлдээж хуримтлуулаагүй.

2.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын журам зөрчигдөх, төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3-д "Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана" гэсэн заалттай нийцүүлж, сар бүрийн батлагдсан төсвийн 30-аас доошгүй хувийн нөөцийг бүрдүүлж, зориулалтын арга хэмжээнд зарцуулах бэлэн байдлыг хангаж байх. Дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

3.1. Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулагдсан бараа материалын шинжтэй эд зүйлийг няравын тайлан, тооцооны дансаар дамжуулахгүй шууд зарлагдсан байна.

3.2. Эрсдэл: Дотоод хяналт сулрах, НББ-ийн зарчим, стандарт хэрэгжихгүй байх эрсдэлтэй

3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэсэн заалттай нийцүүлж бараа материалын бүхий л орлого, зарлагыг бараа материалын тооцооны дансаар дамжуулан бүртгэж тайлагнах. Дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

4.1. Илрүүлэлт: Санхүүгийн программд үндсэн хөрөнгийн ашиглагдах жил буруу оруулснаар хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй тайлагнагдсан.

4.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

4.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэсэн заалттай нийцүүлж үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацааг санхүүгийн программд зөв тусгаж, хуримтлагдсан элэгдлийг үнэн зөв тайлагнах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

5. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

5.1. Илрүүлэлт: Бараа материалын зарцуулалтад бүртгэлээр хэрэгжүүлэх хяналт сул, няравын тайлан тооцоо, анхан шатны баримтын бүрдэл иж бүрэн бус, хүчин төгөлдөр байдлыг хангахгүй, хангалтгүй байна.

5.2. Эрсдэл: Дотоод хяналт сулрах, төсвийн хөрөнгө хяналтгүй, үрэлгэн зарцуулагдах эрсдэлтэй

5.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "Төсвийн захирагч нь төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6- д "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй", 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцүүлж бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. Дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

6. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

6.1. Илрүүлэлт: Малын тарилгын актад малчдын утасны дугаар тэмдэглэж хэвшээгүй, Түүнчлэн Хөх дружба МЭҮН-ийн 7000 бог малд ДХХ-ийн 1-р ээлжийн вакцины тарилгын актыг хуулбарлан 2 удаа хийснээр баримт бүрдүүлсэн, мөн тус нэгжийн 800 бод малд хийсэн дуут хавдарын вакцины тоо хэмжээ тарилгын актад тодорхойгүй байна.

6.2. Эрсдэл: Дотоод хяналт сулрах, төсвийн хөрөнгө хяналтгүй, үрэлгэн зарцуулагдах эрсдэлтэй

6.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "Төсвийн захирагч нь төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6- д "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй", 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн

заалттай нийцүүлж, төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. Дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/40/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мянгад сумын Засаг даргын Тамгын газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.	-	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ч.Улаанхүү Э.Номин
2	Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд үлдээж хуримтлуулаагүй.	1350.0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ч.Улаанхүү Э.Номин
3	Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулагдсан бараа материалын шинжтэй эд зүйлийг нярвын тайлан, тооцооны дансаар дамжуулахгүй шууд зарлагдсан байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ч.Улаанхүү Э.Номин
4	Санхүүгийн программд үндсэн хөрөнгийн ашиглагдах жил буруу оруулснаар хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй тайлагнагдсан.	-	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ч.Улаанхүү Э.Номин
5	Бараа материалын зарцуулалтад бүртгэлээр хэрэгжүүлэх хяналт сул, нярвын тайлан тооцоо, анхан шатны баримтын бүрдэл иж бүрэн бус, хүчин	-	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ч.Улаанхүү Э.Номин

	төгөлдөр байдлыг хангахгүй, хангалтгүй байна.				
6	Малын тарилгын актад малчдын утасны дугаар тэмдэглэж хэвшээгүй, Түүнчлэн Хөх дружба МЭҮН-ийн 7000 бог малд ДХХ-ийн 1-р ээлжийн вакцины тарилгын актыг хуулбарлан 2 удаа хийснээр баримт бүрдүүлсэн, мөн тус нэгжийн 800 бод малд хийсэн дуут хавдарын вакцины тоо хэмжээ тарилгын актад тодорхойгүй байна.	2420.0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Ч.Улаанхүү Э.Номин
7	Эд хөрөнгийн тооллого хийсэн боловч, холбогдох тооцоо бодоогүй, тооллогын үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, мөн өмнөх онд сумын дулааны шугам сүлжээний зураг төсвийн ажлыг 13000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч зорилтот ажлыг тухайн зураг төсвөөр хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан, баланс дахь авлага, урьдчилгаа дансны тооцоог харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	13000.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ч.Улаанхүү Э.Номин
8	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ч.Улаанхүү Э.Номин
9	<ul style="list-style-type: none"> •Он дамжин бүртгэгдсээр байгаа 1480.3 мянган төгрөгийн эзэн тодорхойгүй өр төлбөр, •Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 онд хэрэгжүүлсэн хяналт, шалгалтаар ажилчидтай холбоотой 550.0 мянган төгрөгийн авлагад төлбөрийн акт тогтоосныг төсвөөс төлсөн, •Бараа материалын данс бүртгэлд бодитоор оршин байхгүй 2250.0 мянган төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байсан ба сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 20-ны 28 дугаар тогтоол шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хасаагүй байсныг залруулж бүртгэсэн. Өмнө 	4280.3	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Ч.Улаанхүү Э.Номин
		21050.3			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР